

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/2/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2021 он	Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70358033 Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn Аудитор: О.Гантуяа Утас: 70357955 Цахим хаяг: Gantuya.o@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, АРГА зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө	7
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	8
2.8.3 Авлага.....	9
2.8.4 Урьдчилгаа	9
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	10
2.8.6 Бараа материал	10
2.8.7 Үндсэн хөрөнгө.....	11
2.8.8 Өр төлбөр.....	12
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	12
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.11. Шилэн дансны мэдээлэл	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	15
3. Менежментийн захидал.....	12
3.1 Хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудал.....	12
3.2 Балансын данстай холбоотой асуудал.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	17
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	17
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ

	ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.АНАР ТАНАА
ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Урт булаг баг, Ханддоржийн гудамж, Утас/Факс: 70359826 Цахим шуудан: orkhon@audit.gov.mn	
2021.03.25 № 25	
танай -ны № -т	
Аудитын санал дүгнэлт	

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Анар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-аас 2021 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Эрдэнэ, аудитор О.Гантуяа нар гүйцэтгэв.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 157 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бид даатгуулагчдийн итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын цогц үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Ухаалаг ногоон ажлын байр төсөл

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний байгууллагын дотоод процесс үйл ажиллагааг цахим хэлбэрт оруулах, хийгдсэн ажил бүрийн нэгдсэн бүртгэлийн системийг бий болгох, CRM буюу байгууллагын иргэдэд чиглэсэн цахим системүүдийг бий болгоход чиглэсэн цогц програм хангамж болон технологийн дэмшилтэд шийдлүүдийг хамруулсан цогц төсөл хэрэгжүүлж байна.

- Автоматжуулалт, хиймэл оюун ухаанд суурилсан цахим засаглал

Байгууллагын дотоод ERP, CRM-ын цогц системийг бий болгосноор Нэгдсэн бүртгэлийн систем болон байгууллагын нэгдсэн мэдээллийн баазыг /BIG DATA/ үүсгэсэн бөгөөд үүнийгээ ашиглаж олон төрлийн автоматжуулалт, өндөр бүтээмж бүхий цахим засаглалыг хөгжүүлэн нэвтрүүлсэн. Мөн дотоод аудит, процессын хяналт шалгалтыг автоматжуулж, хиймэл оюуны хэрэглээг бий болгосон. Нийгмийн даатгалын хэлтэст 2 төрлийн Роботын процесс автоматжуулалт нэвтрүүлсэн бөгөөд ингэснээр 13 ажилтан албан хаагчийн өдөр бүр олон давтамжтай хийдэг механик бүтэн жилийн ажлыг роботоор 1, 2 сарын дотор хийлгэж байна. RPA бол компьютер дээр дахин давтагдаж хийгддэг ажлыг, урьдчилан зааварласан дүрмийн дагуу гүйцэтгэдэг робот програм болно.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нийгмийн даатгалын хэлтсийн нэгтгэл нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдэн 2018 онд батлагдан мөрдөгдөж байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа болон сангийн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хийсэн хяналт шалгалт байхгүй. Харин хэлтсийн хяналт шалгалт, дотоод аудитын тасаг 2020 онд нийгмийн даатгалын сангийн орлогын сар, улирал бүрийн төлөвлөгөөний биелэлт, түүний гүйцэтгэлд хяналт тавьж 77.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого оруулах төлөвлөгөөтэй байсан ба 80.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого оруулж орлогын төлөвлөгөөг 104.2 хувиар биелүүлсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 70,694.4 сая төгрөгийн 1 хувь буюу 706.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 146,211.4 сая төгрөгөөс 1 хувь буюу 1,462.1 сая төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,257.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,147.2 сая Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,257.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,147.2 сая төгрөг болж 889.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	8,257.7	9,147.2	889.5	10.7
Дүн	8,257.7	9,147.2	889.5	10.7

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 0.57 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 9,146.6 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө, Хадгаламж дансанд үлдэгдэл байхгүй байна

3.5.3 Авлага

Авлага

дансны эхний үлдэгдэл 2,943.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 14,071.7 сая төгрөг болж, 11,127.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.096	0.096	0
Төлбөртэй үйлчилгээний авлага	2,900.0	4,736.5	1,836.5
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	9,295.2	9,295.2
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	43.9	39.9	-4.0
Зээлийн авлага			
Дүн	2,943.9	14,071.6	11,127.7

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 4,736.5 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Үүссэн шалтгаан: хуулийн хугацаанд төлөгдөөгүй аж ахуйн нэгж байгууллагын шимтгэлийн болон акт алдангийн 4736.5 сая төгрөгийн авлага, үүнээс олон жилийн насжилттай 826.3 сая төгрөгийн авлага байна.
- Ковид-19-тэй холбоотой аж ахуйн нэгж байгууллага болон сайн дурын даатгалын шимтгэлээс төр хариуцах чөлөөлөлтийн нийт 8,373.8 сая төгрөг, дэмжлэгийн нийт 921.4 сая төгрөгийн авлага үүссэн байна.
- 2019-2020 онд 2,782.0 сая төгрөгийн авлага байснаас 775.7 сая төгрөгийн авлагыг шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүхийн шийдвэр гарсан аж ахуйн нэгжээс 2020 онд шүүхийн шийдвэртэй 11 байгууллагын 81.4 сая төгрөгийн авлага барагдсан байна.

Эдгээр авлагын 66% нь ковид-19, цар тахалтай холбоотой засгийн газраас гаргасан шийдвэрийн үр дүнд үүссэн 8,373.8 сая төгрөг байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 9.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 34.7 сая төгрөг болж, 25.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэрэг	870.0	2,022.0	1,152.0
Аж ахуйн материал	4,998.9	28,060.2	23,061.3
Сэлбэг хэрэгсэл	1,357.0	2,878.5	1,521.5
Бусад хангамжийн материал	2,148.6	1,768.4	380.2
Дүн	9,374.5	34,729.1	25,354.6

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материалын тайланд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 16,000 ш 18.2 сая төгрөгийн архивын өндөр үелээлийн радио долгион мэдрэгч аж ахуйн материалд бүртгэгдсэнээр бараа материалын үлдэгдэл өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын тодруулга тайлангийн бусад хангамжийн материал дансанд 7,127.2 мянган төгрөгийн үнэт цаасыг дээд шатны байгууллагаас шилжүүлэн авч зарцуулсан ч орлого зарлагын дэлгэрэнгүй тайланг гаргаагүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 648.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 632.6 сая төгрөг болж 16.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж	483.9	468.8	15.1
Тээврийн хэрэгсэл	7.1	0.0	7.1
Машин тоног төхөөрөмж	45.5	52.5	7.0
Тавилга, эд хогшил	19.9	11.7	8.2
Программ хангамж		7.0	7.0
Биет бус хөрөнгө	92.5	92.5	0.0
Дүн	648.9	632.6	16.3

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгөд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1.0 сая төгрөгийн компьютер, дээд шатны байгууллагаас шилжүүлэн авсан 25.4 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 0.45 сая төгрөгийн тавилга эд хогшил, аймгийн ЗДТГ-аас 11.6 сая төгрөгөөр RPA автоматжуулалт, RPA роботыг хандиваар авч нэмэгдсэн, нийгмийн даатгалын ерөнхий газрын шийдвэрээр 34.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 13.2 сая төгрөгийн тавилга эд хогшил нийт 47.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

RPA робот автоматжуулалтыг авч ашигласнаар нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын гүйлгээг харилцах программд шивж оруулах процесс ажиллагааг хөнгөвчилж, ажилтнаас 3.3 дахин хурдан бөгөөд тасралтгүй ажиллаж, сангийн нягтлан бодогчдийн ажлыг хөнгөвчилж байна.

Аудитын илрүүлэлт:

Дээд шатны байгууллагаас ирсэн 25.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авахдаа ҮХ-1 маягтыг хөтлөөгүй, үндсэн хөрөнгийн биш, бараа материалын тайланд орлогын падаанаар орлого авч албан хаагчдад шаардах хуудсаар зарлагдаж карталсан байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 118.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 620.5 сая төгрөг болж, 502.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн				
Тэтгэвэр, тэтгэмжийн сангийн өглөг	7.7	386.8	379.1	
ААНБ болон СДДаатгуулагч эхэд өгөх өглөг	110.8	233.6	122.8	
Нийт дүн	118.5	620.5	502.0	

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 367.6 сая төгрөгийн тэтгэмжийн сангийн өглөг, 6.5 сая төгрөгийн тэтгэврийн сангийн өглөг, 12.7 сая төгрөгийн бусад сангийн өглөг, 69.8 сая төгрөгийн ААНБ-ын урьдчилж төлсөн шимтгэлийн өглөг, 137.5 сая төгрөгийн сайн дурын даатгуулагчийн урьдчилж төлсөн шимтгэлийн өглөг, 26.3 сая төгрөгийн бусад урьдчилж төлсөн шимтгэлийн өр байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 11,741.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 23,265.6 сая төгрөг болж, 11524.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал				
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	357.1	357.1	0	
Өмч /төрийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	11,309.9	22,834.2	11,524.3	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74.3	74.3	0	
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	11,741.3	23,265.9	11,524.3	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 23,265.9 сая төгрөг болж 11,524.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

- Хуримтлагдсан үр дүн 22,834.2 сая төгрөг болж 11,524.3 сая төгрөгөөр өссөн нь шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд дээд шатны байгууллагаас авсан санхүүжилт, мөн төвлөрүүлэлт, өмнөх онд үүссэн илүү төлсөн НДШ-ийн буцаалтын гүйлгээ зэргээс шалтгаалж, бүртгэгдсэн 23.8 сая төгрөгийн алдааны залруулга байна.

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted Table

Formatted: Right, Space After: 0 pt

Formatted: Font: (Default) Arial, 10 pt, Bold, Mongolian (Mongolia)

3.5.10 Орлогын данс

Үндсэн үйл ажиллагааны орлогод 5 сангийн алдангийн орлого 30.7 сая төгрөг, сангийн бусад болон торгуулийн орлого 23.2 сая төгрөг нийт 53.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор архивын лавлагаа болон ААНБ-ын тодорхойлолтын үнэ 1.2 сая төгрөг орсон байна.

3.5.11 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 4409.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд нийгмийн даатгалын сангийн нийт орлогыг 75,169.4 сая төгрөгөөр, зарлагыг 145,743.9 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 892.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 892.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийгмийн даатгал сангийн орлогыг 8643.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 83,812.6 сая төгрөгөөр, зарлагыг 37355.2 сая төгрөгөөр бууруулж 108,388.7 сая төгрөгөөр, үйл ажиллагааны төсвийг 224.8 сая төгрөгөөр бууруулж 668.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь нийгмийн даатгалын үйл ажиллагааны төсвөөс цалин, НДШ, бусдаар гүйцэтгүүлэх зардлуудыг бууруулж баталсан байна.

Оны эцэст “2020 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 12 сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор төсвийг тодотгож үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг 588.3 тэрбум төгрөгөөр баталсан байна. Орхон аймгийн нийгмийн даатгалын сангийн орлогыг 6,666.7 сая төгрөгөөр бууруулж 77,145.9 сая төгрөгөөр, зарлагыг 3,276.8 сая төгрөгөөр бууруулж 105,111.9 сая төгрөгөөр, байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг 6.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 674.9 сая төгрөгөөр тодотгож өөрчилсөн байна. 5 сангаас ҮОМШӨ-ний сангийн орлогын төлөвлөгөөг оны эхний 8,216.2 сая төгрөгөөс 3,291.8 сая төгрөгөөр бууруулж, 4,924.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийгмийн даатгалын сангийн орлогыг 77,145.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 85,277.6 сая төгрөгийн орлогыг оруулж 8,131.7 сая төгрөгөөр давуулан сангийн орлого 110.5%-иар биелсэн, сангийн зарлагыг 104,436.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 103,682.2 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 99.2%-тай гарсан байна.

Тайлант онд 1354 ажил олгогч байгууллагын 27837 даатгуулагчийн 85,277.3 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг санд төвлөрүүлсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад шинээр 122 аж ахуйн нэгж хамрагдсан байна. Гэвч ковид-19 цар тахалтай холбоотой аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа доголдож, эдийн засгийн хямралаас үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан 173 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаагаа зогсоосон байна.

Сангийн орлогын төлөвлөгөө давж биелсэн шалтгаан нь даатгуулагчийн тоо өмнөх оноос 7512 хүнээр буюу 21.2%-иар буурсан ч Засгийн газрын 2019 оны “төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472-р

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

тогтоол хэрэгжсэнээр даатгуулагчийн дундаж цалин 1,067.0 мянган төгрөгөөр өссөн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420.0 мянган төгрөг болсонтой холбоотой байна.

Сангийн зардал батлагдсан төсвөөс тэтгэвэрийн даатгалын сан 74.8 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сан 0.07 сая төгрөгөөр хэтэрсэн, ҮОМШӨ-ийн даатгалын сан 500.5 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сан 329.1 сая төгрөгөөр хэмнэгдэж нийт дүнгээрээ хэтрээгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 674.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 674.9 сая төгрөгийг урсгал зардалд, зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 674.9 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас нийт 674.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй ч туслах үйл ажиллагааны орлогоор архивын лавлагаа болон ААНБ-ын тодорхойлолтын үнэ, хүүгийн орлого 1.2 сая төгрөг орсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 667.0 сая төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалин, байр ашиглалтын зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлуудын хэмнэлтээс шалтгаалсан байна. Үүнд:

Нэмэгдэл цалин болон унаа хоолны хөнгөлөлтийн зардлаас 4.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 1.0 сая төгрөг, хангамжийн бараа материал, эд хогшил, урсгал засвар, томилолт, бусад урсгал шилжүүлэг зардлуудаас 0.2 сая төгрөг нийт 7.9 сая төгрөгийн зардал хэмнэгдсэн байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 7.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 1.2 сая төгрөг нийт 9.1 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гадаад төсөл хөтөлбөрөөс 8.3 сая, Засаг даргын нөөц хөрөнгийн сангаас 64.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 3.7 сая, нийт 76.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс гадаад төсөл хөтөлбөрийн зардалд 8.3 сая, Засаг даргын нөөц хөрөнгийн сангаас Нийгмийн даатгалын төлөөлөгч хөтөлбөрийн цалингийн зардалд 64.1 сая, Дээд шатны төсвийн захирагчаас олгосон урамшууллын зардал 3.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 109.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 134 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 15 мэдээллийг хугацаа хоцроож, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргаагүй, хамааралгүй гэж мэдээлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 0.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 0.97 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 179.8 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	0.1	1	0.1			100
Албан шаардлага	2	0.97	2	0.97			100
Зөвлөмж	4	179.8	3		1	179.8	75
Нийт	7	180.8	6	1.07	1	179.8	91.6

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн байгууллага, нийгмийн даатгалын сангийн нийт 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргасан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 28,237.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,409.0 сая төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 23,828.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулагдсан алдаа гараагүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөөгүй, оны эцсээр НДҮЗ-ийн 2020.12.18-ны өдрийн 09 тоот тогтоолоор төсөвт тодотгол хийж үндсэн цалингийн зардалд 18.0 сая төгрөг хуваарилсныг 5 албан хаагчдад үндсэн цалингаар тооцож нэмэгдэл хөлс 4.4 сая төгрөгийг олгосон байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

Төвлөрүүлэн захирагчид 23,828.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нийгмийн даатгалын сангийн авлага, өр төлбөрийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 132 мэдээлэл хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 15 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргаагүй, хамааралгүй гэж мэдээлсэн байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэсэн заалтыг хэрэгжүүлж, тогтоосон хугацаанд мэдээллийг бүрэн мэдээлж байх.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалын тодруулга тайлангийн бусад хангамжийн материал дансанд 7127.2 мянган төгрөгийн материалыг дээд шатны байгууллагаас шилжүүлэн авч зарцуулсан ч орлого зарлагын дэлгэрэнгүй тайланг гаргаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" заалтуудыг хэрэгжүүлж, бараа материалын дэлгэрэнгүй тайланг гаргаж байх.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээд шатны байгууллагаас ирсэн 16,701.4 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг орлого авахдаа НХМаягт ҮХ-1 маягтаар хөтлөөгүй, үндсэн хөрөнгийн тайланд биш, бараа материалын тайланд орлогын падаанаар орлогод авч албан хаагчдад картлахдаа шаардах хуудсаар зарлагдсан байна.

3.3.2 Эрсдэл:

Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит



Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" заалтуудыг хэрэгжүүлж, үндсэн хөрөнгийн тайланд УХ-1 маягтаар орлого авч баримтжуулан, тайлагнаж байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар 2021.03.25-ны 212 тоот албан бичгээр хариуг ирүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

ХЯНАСАН: ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		АУДИТЫН ТАЙЛАНГ	Ц.НАРМАНДАХ	Огноо:
АУДИТЫН МЕНЕЖЕР			Б.ЭРДЭНЭ	Огноо:
БЭЛТГЭСЭН: АУДИТОР			О.ГАНТУЯА	

ОРА-2021/2/СТА-ТТЗ

13

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:
ОРА-2021/2/СТ

Аудитын
нэр:

Нийгмийн даатгалын сангийн
нэгтгэсэн санхүүгийн тайлан

Аудитын код:

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2021.03.25

ОРА-2021/2/СТА-ТТЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн
нэгтгэл

Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 132 мэдээлэл хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 15 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргаагүй, хамааралгүй гэж мэдээлсэн байна.		Зөвлөмж	Дарга, ахлах нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд
2	Бараа материалын тодруулга тайлангийн бусад хангамжийн материал дансанд 7127.2 мянган төгрөгийн материалыг дээд шатны байгууллагаас шилжүүлэн авч зарцуулсан орлого зарлагын дэлгэрэнгүй тайланг гаргаагүй байна.	7,127.2	Зөвлөмж	Дарга, ахлах нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд
3	Дээд шатны байгууллагаас ирсэн 16701.4 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг орлого авахдаа НХМаягт ҮХ-1 маягтаар хөтлөөгүй, орлогын падаанаар орлогод авч албан хаагчдад картлахдаа шаардах хуудсаар олгосон байна.	16,701.4	Зөвлөмж	Дарга, ахлах нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөөгүй, НДҮЗ-ийн 2020.12.18-ны өдрийн 09 тоот тогтоолоор төсөвт тодотгол хийж үндсэн цалин дээр 18.0 сая төгрөг орж ирснийг Засгийн газрын 382 дугаар тогтоолыг зөрчиж 5 албан хаагчдад үндсэн цалингаар тооцож илүү цагийн нэмэгдэл 4,409.0 мянган төгрөгийг олгосон байна.	4,409.0	Албан шаардлага	Дарга, ахлах нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд
	Дүн	28,237.6			

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТЫГ

Ц.НАРМАНДАХ

Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 63/63 ОАА-2021/02/СТА-ТТЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөөгүй, оны эцсээр НДҮЗ-ийн 2020.12.18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор төсөвт тодотгол хийж үндсэн цалингийн зардалд 18,000.0 мянган төгрөг хуваарилсныг 5 албан хаагчид үндсэн цалингаар тооцож нэмэгдэл хөлс 4,409.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", 2 дугаар хавсралтын 3.3-т "илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10%-иас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нэмэгдэл хөлсийг тооцож илүү олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Анар, нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... О.ГАНТУЯА